



**EUROCHAMBER MONGOLIA**

ЕВРОП МОНГОЛЫН ХАМТАРСАН ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ  
ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШУУД БУС ТАТВАР  
ШИЛЖҮҮЛЭХ ЖУРМЫН ТАЛААР**

**БАЙР СУУРЬ ИЛЭРХИЙЛСЭН БАРИМТ БИЧИГ**

**2022 ОНЫ 11-Р САР**



## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШУУД БУС ТАТВАР ШИЛЖҮҮЛЭХ ЖУРМЫН ТАЛААР БАЙР СУУРЬ ИЛЭРХИЙЛСЭН БАРИМТ БИЧИГ**

**2022 оны 11 дүгээр сар**

### **Холбогдох салбарууд**

Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд эцсийн эзэмшигчийг өөрчлөх “шууд бус шилжүүлгийн татварын дүрэм” (“ШБШТД”) үйлчилдэг.

Одоогийн хүчин төгөлдөр байгаа хуульд өөрчлөлт оруулах зөвлөмж

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгийг татварын зорилгоор үнэлэх аргачлалыг өөрчлөх
2. **ШБШТД** дэх суутгалын түвшинг бизнесийн ердийн зардлыг оруулах зорилгоор өөрчлөх

### **1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд ашигладаг аргачлалууд**

#### **Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэ цэнийг дараах аргуудыг үндэслэн тооцно**

- Зардалд суурилсан арга
- Орлогод суурилсан арга (төслийн үнэ, жишээлбэл техник эдийн засгийн үндэслэлд заасан)
- Гэрээний үнийн арга (худалдан авагч болон худалдагчийн тохиролцсон хэлцлийн үнэ)

#### **Хайгуулын тусгай зөвшөөрөл**

Хоорондоо хамааралгүй этгээдүүдийн хооронд тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн үнийг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэд суурилсан аргаар тооцно. Харин гэрээний үнэ нь тус аргаар тооцоолсон үнийн дүнгээс 20 ба түүнээс дээш хувиар бага байх тохиолдолд тусгай зөвшөөрлийн үнэлгээний журмаар тодорхойлно:

- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой нөөцийг Эрдэс баялгийн зөвлөлөөс А, В гэж ангилсан тохиолдолд орлогод суурилсан аргад суурилна,
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хайгуулын зардал нь Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын зардлын доод хэмжээнээс тухайн актад заасан хувиар хэтрээгүй тохиолдолд зах зээлийн аргаар тооцсон үнийн дүнгийн дундаж болон зардалд суурилсан аргыг хэрэглэнэ,
- Бусад бүх тохиолдолд зардалд суурилсан аргыг хэрэглэнэ. Бидний мэдэж байгаагаар, үнэлгээнд ямар ямар зардлуудыг оруулж болох тал дээр ТЕГ нэлээд уян хатан ханддаг.

#### **Ашиглалтын тусгай зөвшөөрөл**

Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хоорондоо хамааралгүй этгээдүүд хоорондоо шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн үнийг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээний үнэд үндэслэн тооцно. Харин гэрээний үнэ нь орлогод суурилсан аргаар тооцсон үнийн дүнгээс 20 ба түүнээс дээш хувиар бага байвал орлогод суурилсан аргыг хэрэглэнэ. Орлогод суурилсан аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд зардалд суурилсан аргыг хэрэглэнэ.

#### **ШБШТД-ийг хэрэгжүүлэхэд ажиглагдсан ерөнхий асуудлууд**

- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлсний орлогод татвар ногдуулахдаа Татварын Ерөнхий Газар (ТЕГ) нь тусгай зөвшөөрлийг өөрийн



үнэлгээний аргачлалаар үнэлэх эрхтэй бөгөөд худалдан авсан үнэд суурилах албагүй байдаг.

- Шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн үнэлгээ нь худалдах худалдан авах үнэд суурилагагүй тохиолдолд ТЕГ-аас татвар ногдуулахад ТЕГ-ын үнэлгээ болон худалдан авагч, худалдагчийн тохиролцсон үнэлгээний хооронд зөрүү гарах магадлал өндөр байна гэсэн үг.
- Татварыг үнэлгээний үнийн дүнд ногдуулах тул дээрх тохиолдолд ногдох татварын хэмжээ буруу болно.
- ТЕГ нь ашигт малтмалын үнэлгээ хийхдээ идэвхтэй үүрэгтэй оролцдог. МТА-ны үүрэг нь зөвхөн хэвийн бус үнэлгээг шалгах бус, идэвхтэй үүрэг гүйцэтгэн, өөрсдийн үнэлгээг хийх хууль ёсны эрхтэй байдаг. Худалдан авагч болон худалдагчийн тохиролцсон үнэ нь хэлцлийн бодит үнэ гэдгийг нотлох баримт байсан ч ТЕГ өөрсдийн тогтоосон үнэлгээг өөрчлөх албагүй.
- Бидэнд байгаа мэдээллээр ТЕГ-ын энэхүү үнэлгээний арга нь бусад улс оронд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх татварын бодлогоос өөр байгаа юм. ТЕГ ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс өөр төрлийн хөрөнгөд ингэж өөрийн үзэмжээр үнэлгээний аргачлалуудыг хэрэглэдэггүй болов уу.
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгийн үнэ өөр аргачлалаар тогтоогдсон үнэлгээнээс өндөр байвал ТЕГ шилжүүлгийн үнэн дээр суурилсан аргачлалыг хэрэглэхгүй, харин доор байвал хэрэглэнэ. Энэ нь Монголд олборлолт, хайгуулын чиглэлээр амжилттай ажиллаж, тусгай зөвшөөрлөө ашигтайгаар зарж борлуулж чадсан компаниудад шударга татвар ногдох боломжтой гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Харин тэд ашиггүй ажиллаж мөнгөө алдсан бол татвар нь харьцангуй өндөр байх болно. Өөрөөр хэлбэл, хайгуул, олборлолтын ажилд амжилт олоогүй учраас ТЕГ-аас шийтгэж таарах гээд байна.

### **Түүхэн өртгөөр нь үнэлэх аргачлалтай холбоотой асуудлууд**

Хайгуул, уул уурхайн үйл ажиллагаа өндөр эрсдэлтэй гэдгийг бүгд мэддэг билээ. Эдгээр эрсдэл нь уул уурхай, хайгуулын компаниудаас үл шалтгаалах гадаад хүчин зүйлс болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалдаг.

Өндөр эрсдэл гэдэг нь бизнесүүд оруулсан хөрөнгөө эргүүлэн авч чадахгүй байх магадлал өндөр байхыг хэлнэ. Хайгуул бол эхний шатны үйл ажиллагаа бөгөөд ашиглалт шиг хожуу үеийн үйл ажиллагаанаас илүү өндөр эрсдэлтэй байдаг. Гэхдээ хайгуул, олборлолт хоёулаа өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа гэж тооцогддог.

Эрсдэл нь зөвхөн бизнестэй холбоотой биш, хөрөнгийн үнэлгээ, тэр дундаа ашиглалтын болон хайгуулын хөрөнгийн үнэлгээтэй холбоотой. Үнэлгээ нь тогтворгүй байдаг. Ашиглалтын болон хайгуулын хөрөнгийн үнэлгээ нь ашигт ажиллагаанаас үл хамааран маш өндөр, заримдаа ашигтай ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд ч үнэлгээ бага байж болно. Түүхий эдийн үнэ болон биржээр арилжаалагдаж буй ашиглалтын болон хайгуулын компанийн хувьцааны үнэ тогтворгүй байгаа нь хөрөнгийн үнэлгээ тогтворгүй байдгийг харуулж байдаг. ТЕГ-ын тогтмол үнэлгээний арга зүй нь худалдагч, худалдан авагч талуудын хоорондын зах зээлд суурилсан үнэлгээнд нөлөөлж буй бүх хүчин зүйлийг тусгах хэзээ ч боломжгүй.

Түүхэн өртгөөр үнэлэх аргаар бол хэрвээ компани хайгуулд хөрөнгө оруулалт хийж тусгай зөвшөөрлөө зарсан тохиолдолд наад зах нь тэр мөнгөө бүгдийг нь буцааж авна гэж үздэг. Ийм бизнес эрсдэлгүй бизнес байх болно. Энэ нь аливаа бизнест, ялангуяа хайгуулын бизнест байхгүй нь ойлгомжтой.

### **Ашиглалтын тусгай зөвшөөрлийг ТЭЗҮ-д тусгагдсан төслийн үнээр үнэлэхтэй холбоотой асуудал**

Уул уурхайн компаниуд ТЭЗҮ-д тусгагдсан төслийн үнэлгээг урамшуулалтай ч бай, хөнгөлөлттэй ч бай тогтоохдоо аль алины хувьд ихээхэн хэлбэлзэлтэй арилжаалах нь түгээмэл байдаг.

Гэсэн хэдий ч уул уурхайн компанийн үнэлгээг урамшуулалтай гэхээсээ илүү хөнгөлөлттэй үнээр арилжаалах нь түгээмэл байдаг. Гадаадын биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын судалгааг үзвэл энэ үнэлгээний зөрүү тод харагдана.

Ихэнх тохиолдолд ТЭЗҮ-ийн үнэлгээ нь сурталчилгааны зорилгоор өөдрөгөөр тогтоогдсон байдаг. Төслийн үнийг өсгөхийн тулд ихэвчлэн хөнгөлөлтийн хувь хэмжээ нь компанийн хөрөнгийн бодит өртгөөс доогуур байдаг.



Үүнээс гадна үнэлгээ хийсэн цаг хугацааны хүчин зүйл гэж үргэлж байдаг. Уул уурхайн бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ болон бусад олон асуудал нөлөөлдөг.

Эдгээр хүчин зүйлүүд нь уул уурхайн бизнесийн үнэ цэнэд өдөр тутам нөлөөлдөг бөгөөд ТЭЗҮ-д тусгасан үнэлгээ нь үнэлгээ хийж буй өдрийн үнэлгээнээс даруй хуучирсан байх магадлалтай.

## **2. ШБШТД-ийн суутгалууд**

Одоогийн хүчин төгөлдөр байгаа хуулинд:

Суутгагдах зардалд тусгай зөвшөөрөл авах зардал орно, үүнд (а) тусгай зөвшөөрөл худалдан авах, эзэмшихэд Засгийн газарт төлсөн төлбөр, (б) тусгай зөвшөөрлийг өмнөх эзэмшигчээс худалдаж авсан бол худалдан авахад төлсөн төлбөр. Хайгуулын зардал зэрэг бусад зардал хасагдахгүй.

### **Суутгалуудыг хязгаарлахтай холбоотой асуудлууд**

Хасагдах шаардлагатай зардлуудыг, ялангуяа хайгуулын зардлыг орхигдуулсан нь практик байдал дээр хамгийн чухал зардлыг орхигдуулсан гэсэн үг юм. Үүний үр дүнд ШБШТД нь цэвэр дүнгийн татвар гэхээсээ илүүтэйгээр нийт дүнгээс тооцоолсон татвартай үйлчилж байна.

Ихэнх татваруудыг цэвэр дүнд ногдуулдаг бөгөөд алдагдалтай ажиллаж байгаа компаниуд гэхээсээ илүү ашиг олж байгаа компаниудад татвар ногдуулах нь зөв гэж үздэг билээ. Өмнө дурьдсанчлан олборлолт, хайгуул нь өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа бөгөөд зарим компаниуд алдагдал хүлээж болзошгүй байдаг.

ШБШТД нь хувьцааны борлуулалтад хамаарах цорын ганц татвар биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Монгол Улсад аж ахуйн нэгж болон хувь хүн хувьцаа борлуулахад борлуулалтын ашигт нь орлогын албан татвар ногдуулдаг бөгөөд эдгээр аж ахуйн нэгж болон хувь хүмүүс оршин суугч бус тохиолдолд татварыг суутган шилжүүлдэг.

### **Дүгнэлт**

Европ Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим нь хайгуул, уул уурхайн салбарт тодорхой, тэгш, хөрөнгө оруулалтыг дэмжих татварын тогтолцоог хөгжүүлэхийг дэмждэг.

ШБШТД-ийн үнэлгээний аргачлалын эсрэг үндэслэлүүд нь дээр дурдсан үндэслэлүүдээр хязгаарлагдахгүй. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд ашигладаг үнэлгээний аргачлалууд тодорхой байдаг бөгөөд энэ нь аргачлалыг зохих ёсоор тусгасан байдаг гэсэн үг. Гол асуудал бол ашиглаж байгаа үнэлгээний аргууд нь үнэлгээний гажуудал үүсгэж, татварыг шударга бус ногдуулахад хүргэдэг нь олон тооны жишээн дээр нотлогдож байна.

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгийг үнэлэх зөвлөмж.** ТЕГ нь ашигт малтмалын лицензийн шилжүүлгийг үнэлэхдээ худалдах/худалдан авах үнийг ашиглах ёстой. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгийг үнэлэхдээ МТА өөрийн аргачлалыг хэрэглэх эрхтэй байх ёсгүй.

**ШБШТД-ийн хасалтуудын талаархи зөвлөмж.** ШБШТД-ийн хасалт нь ШБШТД-ийн тодорхой хязгаарлалтууд тавьсан журмаас илүү татварын ерөнхий дүрмийг дагаж мөрдөх нь зүйтэй.